



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 5/01

Мандалговь

Цалин хөлс шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 472 дугаар тогтоолын 1-р заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус байгууллагын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний ажилтнуудын цалин хөлс, мөн жилийн эцсийн ажлын үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээгээр ур чадварын нэмэгдэл, байгууллагын нийт ажилтнуудын хоолны мөнгийг хавсралтаар баталсугай.

2. Шинэчлэн тогтоож буй цалин хөлс болон ур чадвар, бусад нэмэгдлүүдийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр тооцон олгохыг ня-бо М.Мөнгөншагайд үүрэг болгосугай.

ДАРГА

А.ПҮРЭВСҮРЭН



482001001



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар Б/02


Мандалговь

Ээлжийн амралтын хуваарь гаргах
тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус байгууллагын ажилтнуудын ээлжийн амралтын хуваарь, амрах хоногийн тоог хавсралтаар баталсугай.
2. Ажилтнуудын ээлжийн амралтын мөнгийг тооцон олгохыг ня-бо М.Мөнгөншагайд зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ПҮРЭВСҮРЭН

482001004



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 5/03

Мандалговь

Ажил хавсран гүйцэтгүүлэх
тухай

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43 дугаар зүйлийн 3.4 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус байгууллагын чанарын баталгаажуулалтын шинжээч Д.Дэнсмаа жирэмсний амралтаа авсан тул энэхүү албан тушаалд тус байгууллагын стандартын салбар сангийн ажилтан Б.Бямба-Оюуныг 2020 оны 03 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн түр хугацаагаар томилон ажиллуулсугай.
2. Энэхүү ажиллах хугацаанд Б.Бямба-Оюуны цалинг ТЗ-5-2 шатлалын 40%-иар тооцон сар бүр олгохыг ня-бо М.Мөнгөншагайд зөвшөөрсүгэй.

ДАРГА

А.ПҮРЭВСҮРЭН



482001008



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 17 өдөр

Дугаар Б/04

Мандалговь

Удаан жилийн нэмэгдэл олгох
тухай

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дэх заалтыг
үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус байгууллагын жижүүр Р.Мөнхдалайгийн удаан жилийн нэмэгдлийг
үндсэн цалингийн 25%-иар тооцон олгосугай.

2. Энэхүү нэмэгдлийг тооцон олгож байхыг ня-бо М.Мөнгөншагайд
зөвшөөрсүгэй.

ДАРГА



А.ПҮРЭВСҮРЭН

82001009